

ДИ БИ ЭМ лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Санхүүгийн тайлан

(Хараат Бус Аудиторын Тайлангийн Хамт)

Агуулга

	Хуудас
Компанийн Мэдээлэл	1
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл	2
Хараат Бус Аудиторын Тайлан	3
Санхүүгийн Байдлын Тайлан	6
Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	7
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	8
Мөнгөн Гүйлгээний Тайлан	9
Санхүүгийн Тайлангийн Тодруулга	10

ДИ БИ ЭМ ЛИЗИНГ ХХК

Компанийн мэдээлэл

Албан ёсны хаяг	Энхтайваны өргөн чөлөө, 12 давхар Сүхбаатар дүүрэг, 1-р хороо Улаанбаатар 14210 Монгол Улс
Хувьцаа эзэмшигч	Монгол Улсын Хөгжлийн Банк (100%)
Хараат бус аудитор	Кэй Пи Эм Жи Аудит ХХК Монгол Улс, Улаанбаатар хот 14240 Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо Энхтайваны өргөн чөлөө Блю Скай Тауэр, 602 тоот

Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Ди Би Эм Лизинг ХХК ("Компани")-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Компанийн удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Компанийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах зохистой нягтлан бодох бүртгэлийг компани нь хөтлөн явуулж байгаа гэдгийг компанийн удирдлагууд баталгаажуулах үүрэгтэй ба энэ нь тодруулга 2-оос 5-д дурьдсан шаардлагуудад нийцсэн байх хэрэгтэй.

Мөн Компанийн удирдлага нь Компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг тодруулгын хамт бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, бүх холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Компанийн удирдлагаас Ди Би Эм Лизинг ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.




З. Авирмэд
(Нягтлан бодогч)

Монгол Улс,
Улаанбаатар хот

2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17,
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс : +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бус Аудиторын Тайлан

Ди Би Эм Лизинг ХХК-ийн Хувьцаа Эзэмшигчид:

Дүгнэлт

Бид Ди Би Эм Лизинг ХХК (цаашид “Компани” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд ба бусад тайлбар мэдээллүүдийг агуулсан тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, энэхүү санхүүгийн тайлан нь Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан СТОУС-ын Стандартууд (цаашид “СТОУС-ын Стандартууд” гэх)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн Үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн *Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага* хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Дүрэм (Хараат Бус Байдлын Олон Улсын Стандарт үүнд хамаарна) (цаашид “НБЁЗОУСЗ-ийн Ёс зүйн Дүрэм” гэх) болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу Компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт өгөхөд хангалттай бөгөөд зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.

Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн Тайланд Хүлээх Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын Стандартуудын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Алдаа, зальт ажиллагааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх үүрэг хариуцлагыг мөн удирдлага хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс Компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, Компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг Компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.



Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж гаргах, мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь Компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.



Санхүүгийн Тайлангийн Аудитад Хүлээх Аудиторын Үүрэг Хариуцлага, Үргэлжлэл

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Кэй Пи Эм Жи Аудит ХХК

Аудитор ООХ

Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2023 оны 6 дугаар сарын 15-ны өдөр

Баталгаажуулсан:

С.С.

Г. Соёлмаа
Ерөнхий Захирал

Баталсан:

PS Kong

Гун Пёншиг
Партнер

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

Ди Би Эм Лизинг ХХК
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
 Санхүүгийн Байдлын Тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Тодруулга</u>	<u>2022</u>	<u>2021</u>
Хөрөнгө			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	6	47,610,547	9,938,358
Хугацаатай хадгаламж	7	-	27,974,372
Дансны болон бусад авлага	8	189,334	2,146
Түрээсийн авлага	9	67,115,271	71,145,041
Бусад хөрөнгө		216	1,048
Үндсэн хөрөнгө	10	133,657	165,053
Биет бус хөрөнгө		7,002	6,494
Нийт хөрөнгө		<u>115,056,027</u>	<u>109,232,512</u>
Өр төлбөр			
Дансны болон бусад өглөг	11	269,759	969,992
Орлогын албан татварын өглөг		2,206,303	1,123,483
Түрээсийн өр төлбөр	12, 22	20,587	55,641
Зээл	13	-	7,157,641
Хойшлогдсон татварын өр төлбөр	20	664,415	82,341
Нийт өр төлбөр		<u>3,161,064</u>	<u>9,389,098</u>
Эздийн өмч			
Хувьцаат капитал	14	100,000,000	100,000,000
Хуримтлагдсан ашиг/ (алдагдал)		11,894,963	(156,586)
Нийт эздийн өмч		<u>111,894,963</u>	<u>99,843,414</u>
Нийт өр төлбөр ба эздийн өмч		<u>115,056,027</u>	<u>109,232,512</u>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Тодруулга</u>	<u>2022</u>	<u>2021</u>
Хүүгийн орлого	15	15,658,986	10,463,295
Хүүгийн зардал	16	<u>(27,948)</u>	<u>(465,458)</u>
Цэвэр хүүгийн орлого		<u>15,631,038</u>	<u>9,997,837</u>
Үйл ажиллагааны зардал	17	(662,520)	(1,049,584)
Бусад орлого/ (зардал), цэвэр	18	<u>7,913,865</u>	<u>(3,182,649)</u>
Үйл ажиллагааны орлого		<u>22,882,383</u>	<u>5,765,604</u>
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	19	<u>(7,511,633)</u>	<u>(3,480,330)</u>
Татварын өмнөх ашиг		<u>15,370,750</u>	<u>2,285,274</u>
Орлогын татварын зардал	20	<u>(3,319,201)</u>	<u>(1,213,727)</u>
Тайлант жилийн цэвэр ашиг болон нийт дэлгэрэнгүй орлого		<u>12,051,549</u>	<u>1,071,547</u>

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Хувьцаат капитал (Тодруулга 14)	Хуримтлагд- сан (алдагдал) / ашиг	Нийт
2021 оны 01 дүгээр сарын 01- ний үлдэгдэл	100,000,000	(1,228,133)	98,771,867
Нийт дэлгэрэнгүй орлого			
Тайлант жилийн цэвэр ашиг	-	1,071,547	1,071,547
2021 оны 12 дугаар сарын 31- ний үлдэгдэл	100,000,000	(156,586)	99,843,414
2022 оны 01 дүгээр сарын 01- ний үлдэгдэл	100,000,000	(156,586)	99,843,414
Нийт дэлгэрэнгүй орлого			
Тайлант жилийн цэвэр ашиг	-	12,051,549	12,051,549
2022 оны 12 дугаар сарын 31- ний үлдэгдэл	100,000,000	11,894,963	111,894,963

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

(Мянган төгрөгөөр)	Тодруулга	2022	2021
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		12,051,549	1,071,547
<i>Тохируулууд:</i>			
Хүүгийн орлого	15	(15,658,986)	(10,463,295)
Хүүгийн зардал	16	27,948	465,458
Ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй (олз)/ гарз, цэвэр	18	(7,622,082)	3,210,139
Үндсэн хөрөнгийн элэгдэл	10	32,724	52,179
Биет бус хөрөнгийн хорогдуулга		1,053	920
Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал	19	7,511,633	3,480,330
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	18	(1,510)	-
Орлогын татварын зардал	20	3,319,201	1,213,727
<i>Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд:</i>			
Дансны болон бусад авлага		(119,596)	3,146
Түрээсийн авлага		18,167,110	10,087,331
Бусад хөрөнгө		832	22,751
Дансны болон бусад өглөг		(711,442)	723,961
Төлсөн орлогын албан татвар		(1,654,307)	(90,244)
Хүлээн авсан хүү		1,613,114	3,286,764
Төлсөн хүүгийн зардал		(133,401)	(907,596)
Үйл ажиллагаанаас олсон цэвэр мөнгөн гүйлгээ		16,823,840	12,157,118
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Хугацаатай хадгаламжаа цуцалсанаас хүлээн авсан		27,988,999	-
Байршуулсан хугацаатай хадгаламж		-	(27,244,809)
Худалдан авсан үндсэн хөрөнгө	10	(3,654)	(5,006)
Худалдан авсан биет бус хөрөнгө		(1,561)	-
Худалдсан үндсэн хөрөнгө		1,800	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		27,985,584	(27,249,815)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Зээлийн эргэн төлөлт	13	(7,076,856)	(11,927,028)
Түрээсийн өр төлбөрийн эргэн төлөлт	22	(40,800)	(40,801)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(7,117,656)	(11,967,829)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/ (бууралт)		37,691,768	(27,060,526)
01 дүгээр сарын 01-ний өдрөөрх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6	9,938,358	36,719,679
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	6	-	663
Гадаад валютын ханшийн хэлбэлзлийн бэлэн мөнгөнд үзүүлэх нөлөө		(19,579)	278,542
12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6	47,610,547	9,938,358

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1. Ерөнхий мэдээлэл

Ди Би Эм Лизинг ХХК (цаашид “Компани” гэх) нь 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Монгол Улсад үүсгэн байгуулагдсан. Компанийг Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК бүрэн эзэмшдэг. Компанийн регистрийн дугаар нь 6196233 болно. Компанийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, 12 дугаар давхар.

Компани нь Монгол Улсын Компанийн тухай хуулийн дагуу хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд Монгол Улсын санхүүгийн түрээсийн тухай хууль, Иргэний хууль, Монгол Улсын Хөгжлийн Банкны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхэлдэг. Компани нь дунд болон урт хугацаатай гэрээний дагуу санхүүгийн түрээсийг олгодог. Компани нь Шинэ сэргэлтийн бодлогод багтсан Монгол Улсын хөгжилд стратегийн чухал ач холбогдолтой салбаруудын төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх замаар Монгол Улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахыг зорин ажилладаг.

2. Санхүүгийн тайлагналын зарчим

(1) Тайланг бэлтгэхэд баримталсан стандарт

Компанийн санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу бэлтгэсэн болно. Санхүүгийн тайланд чухал нөлөө бүхий өндөр түвшний үнэлэмж шаардсан, нарийн төвөгтэй бөгөөд таамаглал, тооцоолол ашиглагдсан хэсгүүдийг Тодруулга 2(5)-д тодруулсан болно.

Тайлант жилийн толилуулгатай нийцүүлэх зорилгоор тодорхой харьцуулагдах дүнг дахин ангилсан.

Санхүүгийн тайланг 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрөөр удирдлага хүлээн зөвшөөрч, баталсан.

(2) Хэмжилтийн суурь

Энэхүү санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад өөрөөр тодруулснаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

(3) Бүртгэлийн болон толилуулгын валют

Энэхүү санхүүгийн тайланг бэлтгэж тайлагнахдаа Компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан ба тусгайлан тодруулснаас бусдаар санхүүгийн тайланг мянгачилж толилуулсан.

(4) Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайлан нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд үндэслэн бэлтгэгдсэн бөгөөд энэ нь Компани ойрын ирээдүйд хөрөнгөө бизнестээ хэвээр үлдээж, өр төлбөрөө төлж, үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулна гэдгийг илэрхийлнэ.

2. Санхүүгийн тайлагналын зарчим, үргэлжлэл

(5) Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд тухайн өөрчлөлт гарсан тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд уг тооцооллын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдсэн таамаглал, тооцоолол, үнэлэмжийн талаарх мэдээлэл болон дараагийн тайлант үед хамаарах материаллаг залруулгын нөлөө бүхий эрсдэлийн үндэслэл болон тооцооллын талаарх мэдээллийг доорх тодруулгад тусгасан:

- Тодруулга 3 (3), 9, 24 – Дансны болон бусад авлагын хүлээгдэж буй алдагдлын хэмжилт: жигнэсэн дундаж алдагдлын түвшинг тодорхойлоход ашигласан чухал таамаглалууд.

(6) Бодит үнэ цэнийн хэмжилт

Хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг тайлагналын зорилгоор жил бүр хянадаг. Уг үнэлгээг хийхдээ Компанийн удирдлага томоохон нөлөө үзүүлэхүйц хэмжээний үл ажиглагдах хүчин зүйлс болон үнэлгээний тохируулгуудыг хянадаг. Бодит үнэ цэнийг үнэлэхдээ хөндлөнгийн этгээдийн мэдээллийг ашиглаж байгаа бол үнэлгээг тогтоохдоо ашигласан мэдээлэл, аргачлал нь санхүүгийн тайлагналын журмын шаардлагад нийцэж байгаа эсэх болон үнэлгээний зорилгод нийцэж байгаа эсэхийг Компанийн удирдлага үнэлдэг.

Компани нь хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ аль болох зах зээлийн мэдээллийг ашигладаг. Үнэлгээнд ямар төрлийн мэдээллийг ашигласнаас хамаарч бодит үнэ цэнийг дараах гурван түвшинд ангилдаг.

- Түвшин 1: Ижил төрлийн хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн жишиг үнэ (залруулаагүй)
- Түвшин 2: Тухайн хөрөнгө, өр төлбөрийн хувьд 1 дүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад өгөгдлүүд, шууд (өөрөөр хэлбэл үнээр) эсвэл шууд бусаар (өөрөөр хэлбэл үнээс үүсэлтэй)
- Түвшин 3: Хөрөнгө эсвэл өр төлбөрийн зах зээлийн ажиглагдахуйц мэдээлэл дээр суурилагүй өгөгдлүүд (үл ажиглагдахуйц өгөгдлүүд)

Хэрэв хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн үнэлгээнд ашиглаж буй өгөгдлүүд нь үнэлгээний өөр өөр түвшинд ангилагдаж байвал бодит үнэ цэнийн үнэлгээг нь түүнд гол нөлөө үзүүлсэн хамгийн бага түвшний өгөгдөлтэй ижил түвшинд ангилна. Бодит үнэ цэнийн өгөгдлийн түвшин хоорондын шилжилтийг Компани нь өөрчлөлт гарсан тайлант үеийн эцэст хүлээн зөвшөөрдөг.

Бодит үнэ цэнийн үнэлгээнд хийсэн таамаглалын талаарх нэмэлт мэдээллийг дараах тодруулгаас харна уу.

- Тодруулга 24 - эрсдэлийн удирдлага

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Компанийн санхүүгийн тайлан гаргахдаа баримталж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогыг дор дурдсан болно. Доор хураангуйлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг энэхүү санхүүгийн тайланд толилуулсан бүх тайлант жилүүдэд тууштай хэрэглэсэн болно.

(1) Гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлж тайлагнадаг.

Борлуулах боломжтой өмчийн хэрэглүүрийн дахин хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүнээс бусад үед гадаад валютын дахин хөрвүүлэлтийн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаарх түүхэн өртгөөрөө хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшаар тайлагнадаг.

(2) Санхүүгийн хэрэглүүр

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө

Компани нь тухайн санхүүгийн хэрэгслийн гэрээний нэг тал болсон тохиолдолд санхүүгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Дансны авлагыг анх үүссэн үед нь анх хүлээн зөвшөөрдөг. Компани нь хэрэглүүрийн гэрээний нөхцөлд нэг тал болсон үед бусад бүх санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө (хэрэв энэ нь санхүүгийн томоохон бүрэлдэхүүн хэсэггүй дансны авлага биш бол) эсвэл санхүүгийн өр төлбөрийг түүний бодит үнэ цэнээр тооцож, ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнэ (ААБҮЦ)-ээр тооцдоггүй зүйлийн хувьд түүнийг худалдан авах эсвэл гаргахтай шууд холбоотой аливаа ажил гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмждэг. Томоохон санхүүгийн бүрэлдэхүүн хэсэггүй дансны авлагуудыг ажил гүйлгээний үнээр анх хэмждэг.

Санхүүгийн хөрөнгүүд

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө хорогдуулсан өртгөөр хэмжсэн; бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБҮЦ)-ээр хэмжсэн өрийн хөрөнгө оруулалт; БДОБҮЦ-ээр хэмжсэн өмчийн хөрөнгө оруулалт; эсвэл ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилдаг.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа тухайн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнес загварыг өөрчилснөөс бусад тохиолдолд дахин ангилахгүй бөгөөд бизнес загварын өөрчлөлттэй холбоотой бүх санхүүгийн хөрөнгийг тухайн өөрчлөлт орсон эхний тайлант жилийн эхний өдөр дахин ангилдаг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг зэрэг хангаж байвал тухайн санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмждэг:

- гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор санхүүгийн хөрөнгийг эзэмшдэг бизнесийн загвартай; болон
- тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөр болон уг төлөгдөөгүй үндсэн төлбөрийн үлдэгдлээс тооцсон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтоосон өдрүүдээр орж ирэх;

Өрийн хөрөнгө оруулалт нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг зэрэг хангаж байвал тухайн өрийн хөрөнгө оруулалтыг БДОБҮЦ-ээр хэмждэг:

- гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмшдэг бизнесийн загвартай; болон
- тухайн санхүүгийн хөрөнгийн гэрээний нөхцөл нь зөвхөн үндсэн төлбөр болон уг төлөгдөөгүй үндсэн төлбөрийн үлдэгдлээс тооцсон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтоосон өдрүүдээр орж ирэх;

Дээр дурьдсан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, эсвэл БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилагдаагүй бусад бүх санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмждэг.

Санхүүгийн хөрөнгүүд – Бизнесийн загварын үнэлгээ

Компани нь бизнес загварын үнэлгээг хийхдээ санхүүгийн хөрөнгийн багцын түвшинд хийдэг бөгөөд энэ нь бизнесийг удирдаж буй арга замыг хамгийн сайн илэрхийлдэг ба удирдлага нь мэдээллээр хангагдсан байдаг. Дараах мэдээллийг харгалзан үзсэн:

- багцын бодлого, зорилтууд, эдгээр бодлогын практик үйл ажиллагаа. Үүнд, удирдлагын стратеги нь гэрээгээрх хүүгийн орлогоо олох, тодорхой хүүний түвшний үзүүлэлтийг хадгалах, санхүүгийн хөрөнгийн үргэлжлэх хугацааг түүнтэй холбоотой аливаа өр төлбөрийн хугацаа эсвэл хүлээгдэж буй мөнгөн зарлагын урсгал эсвэл хөрөнгийг борлуулснаар бий болох мөнгөн гүйлгээтэй тохируулдаг эсэх;
- багцын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж, Компанийн удирдлагад тайлагнадаг эсэх;
- бизнесийн загвар (мөн тухайн бизнесийн загварт багтсан санхүүгийн хөрөнгүүд)-ын гүйцэтгэлд нөлөөлөх эрсдэлүүд болон эдгээр эрсдэлүүдийг хэрхэн удирддаг эсэх;
- бизнесийг удирдаж буй менежерүүдийг хэрхэн урамшуулдаг – жишээ нь урамшуулал тэдний удирдаж буй хөрөнгийн бодит үнэ цэнэ эсвэл цуглуулсан гэрээгээрх мөнгөн урсгалд үндэслэдэг эсэх; болон
- өмнөх тайлант хугацаанд хийгдсэн санхүүгийн хөрөнгийн борлуулалтын давтамж, тоо хэмжээ, цаг хугацаа, эдгээр борлуулалтыг хийсэн шалтгаанууд болон ирээдүйн борлуулалтын үйл ажиллагааны хүлээлт.

Санхүүгийн хөрөнгийг гуравдагч этгээдэд шилжүүлэх ажил гүйлгээ нь тухайн санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөх нөхцлийг хангаагүй тохиолдолд борлуулалт гэж үзэхгүй бөгөөд Компанийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх зарчимтай нийцдэг.

Арилжаалах зорилгоор эзэмшиж буй эсвэл удирдаж байгаа, мөн гүйцэтгэлийг нь бодит үнэ цэнэд суурилан үнэлдэг санхүүгийн хөрөнгүүдийг ААБҮЦ-ээр хэмждэг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгүүд – Гэрээгээрх мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн болон хүүгийн төлбөрөөс бүрддэг эсэх үнэлгээ

Энэхүү үнэлгээний зорилгоор 'үндсэн төлбөр' гэж анхны хүлээн зөвшөөрөлтийн үеийн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийг хэлнэ. 'Хүүгийн төлбөр' гэж мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ, тодорхой нэг хугацаанд үлдэгдэлтэй байгаа үндсэн төлбөрт холбогдох зээлийн эрсдэл болон бусад зээлийн үндсэн үйл ажиллагааны эрсдэл, өртөг (жишээлбэл, төлбөрийн чадварын эрсдэл ба үйл ажиллагааны зардал гэх мэт), мөн түүнчлэн ахиуц ашгийг харгалзан тодорхойлдог.

Санхүүгийн хөрөнгийн гэрээгээрх мөнгөн урсгал нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрөөс бүрдсэн эсэхийг үнэлэхдээ Компани уг санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцлийг авч үздэг. Ингэхдээ гэрээгээрх мөнгөн урсгал орж ирэх хугацаа, эсвэл орж ирэх мөнгөн дүнг өөрчилсөнөөр үндсэн нөхцлөө хангахгүй байх боломжтой гэрээний нөхцөл агуулсан эсэхийг үнэлэх зэрэг багтана. Энэхүү үнэлгээг хийхдээ Компани дараах зүйлсийг авч үздэг:

- мөнгөн урсгалын мөнгөн дүн болон цаг хугацааг өөрчилж болзошгүй үйл явдал;
- хувьсах хувь хэмжээг багтаасан гэрээнд заасан нэрлэсэн хүүгийн түвшинг тохируулах нөхцлүүд;
- урьдчилан төлбөр гүйцэтгэх болон сунгалт хийх нөхцлүүд; болон
- тодорхой хөрөнгүүдээс орж ирэх мөнгөн урсгалыг Компанийн нэхэмжлэх эрхийг хязгаарласан нөхцлүүд (жишээ нь буцаах эрхгүй нөхцлүүд).

Хэрвээ урьдчилгаа төлбөр нь үндсэн төлбөр болон үндсэн төлбөрийн үлдэгдэлд ногдох хүүгийн төлбөрийн төлөгдөөгүй дүн (үүнд гэрээг эрт дуусгавар болгосонтой холбогдон үүсэх нэмэлт нөхөн төлбөр багтана)-ийн дийлэнх хэсгийг илэрхийлж байвал урьдчилгаа төлбөрийн шинж чанар нь зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрийн нөхцөлтэй ижил байдаг. Түүнчлэн, хөнгөлөлттэй үнээр эсвэл гэрээнд заасан урамшуулалтай үнээр худалдан авсан санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хэрэв урьдчилгаа төлбөрийн бодит үнэ цэнэ нь анхны хүлээн зөвшөөрөлтийн үед хангалтгүй бол гэрээгээрх нэрлэсэн дүн болон хуримтлуулсан (гэхдээ төлөгдөөгүй) гэрээний хүүг (гэрээг эрт дуусгавар болгосонтой холбогдон үүсэх нэмэлт нөхөн төлбөр багтаж болно) урьдчилан төлөхийг зөвшөөрсөн эсвэл шаардсан нөхцөл нь дээрх нөхцөлтэй нийцдэг.

Санхүүгийн хөрөнгө – Дараа үеийн хэмжилт болон олз ба гарз

ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайлант үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмждэг. Аливаа хүүгийн орлого эсвэл ногдол ашгийн орлого зэрэг багтсан цэвэр олз ба гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүдийг дараагийн тайлант үеүдэд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмждэг. Хорогдуулсан өртгийг үнэ цэнийн бууралтын гарзаар бууруулдаг. Хүүгийн орлого, гадаад валютын ханшийн олз, гарз ба үнэ цэнийн бууралтыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг. Аливаа үл хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн олз эсвэл гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(i) Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө, үргэлжлэл

Санхүүгийн хөрөнгө – Үл хүлээн зөвшөөрөх

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бодитойгоор шилжүүлсэн бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг. Уг гүйлгээгээр бий болсон эсвэл үлдсэн аливаа эрх, үүргийг тусад нь санхүүгийн хөрөнгө, өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Хэрэв Компани уг шилжүүлсэн санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бодитойгоор өөртөө үлдээсэн бол уг санхүүгийн хөрөнгийг үргэлжлүүлэн хүлээн зөвшөөрөх ба холбогдох санхүүгийн өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах нь

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хаах хууль эрх зүйн эрхтэй байх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компани нь хүлээгдэж буй зээлийн алдагдлын (ХБА) санг дараах санхүүгийн хөрөнгүүдийн хувьд хүлээн зөвшөөрдөг:

- хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгө; ба
- БДОБҮЦ-ээр илэрхийлсэн өрийн хөрөнгө оруулалт.

Компани 12 сарын хугацаанд ХБА-ын хэмжээгээр хэмжигдэх дараахаас бусад тохиолдолд зээлийн алдагдлын санг нийт хугацааны ХБА-ын сантай тэнцэх хэмжээгээр тооцдог:

- тайлагналын өдрөөр зээлийн эрсдэл бага байхаар тодорхойлогдсон өрийн үнэт цаас; болон
- зээлийн эрсдэлтэй бусад өрийн үнэт цаас болон банкны үлдэгдэл (өөрөөр хэлбэл, санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны туршид үүргээ биелүүлэхгүй байх эрсдэл) анх хүлээн зөвшөөрснөөс хойш мэдэгдэхүйц нэмэгдээгүй.

Дансны авлага болон гэрээний хөрөнгийн хувьд алдагдлыг үргэлж 12 сарын болон гэрээний нийт хугацаатай тэнцэх ХБА-тай байхаар хэмждэг.

Санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдэл нь анх хүлээн зөвшөөрснөөс хойш болон ХБА-г тооцох үед мэдэгдэхүйц хэмжээнд нэмэгдсэн эсэхийг тодорхойлохдоо Компани үндэслэлтэй бөгөөд дэмжлэг болох холбоотой бөгөөд аливаа өртөг, хүчин чармайлт гаргалгүй олж авах боломжтой мэдээллийг авч үздэг. Энэ нь Компанийн түүхэн туршлага, мэдээлэлд тулгуурласан зээлийн үнэлгээ болон ирээдүйн мэдээллийг багтаасан тоон болон чанарын мэдээлэл, дүн шинжилгээг багтаадаг.

Компани нь санхүүгийн хөрөнгийн эргэн төлөлтийн хугацаа 30 хоногоос хэтэрсэн тохиолдолд зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн гэж үздэг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

Компани санхүүгийн хөрөнгийг дараах нөхцөлд хугацаа хэтэрч, үүргээ биелүүлээгүй гэж үздэг:

- Компани зээлдэгч нь үнэт цаасыг хүчээр зарах (хэрэв байгаа бол) гэх мэт аливаа арга хэмжээ авахгүйгээр Компанид эргэн төлөх үүргээ бүрэн биелүүлж чадахгүй тохиолдолд; эсвэл
- санхүүгийн хөрөнгө 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн

Гэрээний нийт хугацаа дуусах хүртэлх ХБА нь санхүүгийн хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацааны туршид тохиолдох боломжтой бүхий л хугацаа хэтрэлт буюу үүргийн үл биелэлтээс үүсэх ХБА юм.

12 сарын ХБА нь тайлант жил дуусгавар болсон өдрөөс хойш 12 сарын хугацаанд (эсвэл хэрэглүүрийн хүлээгдэж буй хугацаа нь 12 сараас бага бол түүнээс богино хугацаанд) тохиолдож болзошгүй хугацаа хэтрэлт буюу үүргийн үл биелэлтээс үүсэх нийт хугацааны ХБА-ын хэсэг юм.

ХБА-г тооцохдоо авч үздэг хамгийн урт хугацаа нь Компанийн зээлийн эрсдэлд өртөх гэрээний хамгийн урт хугацаа юм.

ХБА нь зээлийн алдагдлын магадлалаар жигнэсэн тооцоолол юм. Зээлийн алдагдлыг бүх мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмждэг (жишээ нь, гэрээний дагуу аж ахуйн нэгжид учирч болзошгүй мөнгөн гүйлгээ ба Компанийн хүлээж авах мөнгөн гүйлгээний хоорондын зөрүү).

ХБА-ыг санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүүгийн түвшингээр дискаунтлан тооцдог.

Компани хорогдуулсан өртгөөр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө болон БДОБҮЦ-ээр хэмжигдсэн өрийн үнэт цаас нь зээлийн үнэлэмж буурсан эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог. Санхүүгийн хөрөнгийн ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээнд сөрөг нөлөө үзүүлэх нэг буюу хэд хэдэн үйл явдал тохиолдсон бол санхүүгийн хөрөнгийг "зээлийн үнэлэмж буурсан" гэнэ.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бодит нотолгоог харуулах дараах үйл явдлууд байна:

- зээлдэгчийн санхүүгийн нөхцөл байдал нэлээд хэмжээгээр хүндэрсэн;
- 90 хоногоос дээш эргэн төлөх хугацаа хэтэрсэн эсвэл гэрээний үүргээ биелүүлэх чадваргүй болсон зэргээр гэрээний заалтыг зөрчсөн;
- Компанид өөр нөхцөл байхгүй байсантай холбоотой зээл болон урьдчилгаа төлбөрийн бүтцийг өөрчилсөн;
- зээлдэгч нь дампуурал зарлах эсвэл санхүүгийн хувьд дахин зохион байгуулалт хийх магадлалтай;
- санхүүгийн хүнд нөхцөл байдлын улмаас санхүүгийн хөрөнгийн идэвхитэй зах зээл байхгүй болсон

Хорогдуулсан өртгөөр нь хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын нөөц нь тухайн хөрөнгийн нийт дансны үнийг бууруулдаг.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлсэн өрийн үнэт цаасны хувьд үнэ цэнийн бууралтын нөөцийг ашиг, алдагдлын хэсэгт тусган бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт хүлээн зөвшөөрнө.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(3) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

Компанийн санхүүгийн хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нөхөх хангалттай хүлээлт байхгүй тохиолдолд санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнийг данснаас хасна. Байгууллагын харилцагчдын хувьд хугацаандаа эргэн төлөгдөх магадлалтай эсэхэд үндэслэн данснаас хасах хугацаа, дүнг тодорхойлох зорилгоор тусгайлсан үнэлгээг хийдэг боловч данснаас хассан санхүүгийн хөрөнгө нь Компанийн эргэн төлөгдөх хугацаа нь болсон хөрөнгийг эргэн төлүүлэхтэй холбоотой гүйцэтгэдэг горимын дагуу албадлагын ажиллагааг хийх боломжтой.

(4) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анх өртгөөр нь хүлээн зөвшөөрөх бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үндсэн хөрөнгийг тухайн хөрөнгийн өртгөөс аливаа хуримтлагдсан элэгдэл болон аливаа үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр нь бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөгт тухайн хөрөнгийг худалдан авах болон барьж байгуулахтай шууд холбогдон гарсан зардал, мөн удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож түүнийг байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой гарсан бусад зардлууд, мөн тухайн хөрөнгийг задлах, зайлуулах болон байрлаж байсан талбайг нь сэргээн засварлахад гарах зардлуудыг хамааруулна.

Хэрэв үндсэн хөрөнгийн тодорхой хэсгийн элэгдүүлэх хугацаа тухайн үндсэн хөрөнгөөс ялгаатай бол тэдгээрийг үндсэн хөрөнгийн тусдаа зүйл (гол бүрэлдэхүүн) гэж үзнэ.

Компани нь дараа үеийн зардлаас эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай бөгөөд тухайн зардлыг үнэн зөв хэмжих боломжтой болсон үед түүнийг үндсэн хөрөнгийн дансны үнэ дээр нэмэгдүүлэх буюу эсвэл тусдаа хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Солигдсон эд ангийн дансны үнээр хөрөнгийн дансны үнийг бууруулна. Өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн зардал гарсан тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг түүний ирээдүйд авчрах эдийн засгийн үр өгөөжөөс нь хамаарч ашиглагдах жилийнх нь туршид шулуун шугамын аргаар тооцон байгуулдаг. Үндсэн хөрөнгийн нийт өртгийн дүнд багтсан гол бүрэлдэхүүн хэсгийн ашиглагдах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрт тусад нь элэгдэл байгуулдаг.

Үндсэн хөрөнгийг борлуулснаас үүссэн олз, гарзыг борлуулж буй үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэтэй харьцуулж тодорхойлдог бөгөөд бусад үйл ажиллагааны бус орлого (зардал)-оор хүлээн зөвшөөрдөг.

Үндсэн хөрөнгийн зүйлсийн эдийн засгийн ашиглалтын хугацаа дараах байдалтай байна:

Үндсэн хөрөнгийн зүйлс	Тайлант жил
Тээврийн хэрэгсэл	10 жил
Тавилга, эд хогшил	3-10 жил
Компьютер	3 жил

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрт хянаж үзээд шаардлагатай бол залруулдаг. Энэхүү өөрчлөлтийг тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(5) Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Компанийн бараа материал болон хойшлогдсон татварын хөрөнгөөс бусад санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд цэнийн бууралтын аливаа нэг шинж тэмдэг илэрсэн эсэхийг тайлант хугацааны эцэс бүрт үнэлж тодорхойлдог. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлно. Нэгж хөрөнгө эсвэл мөнгөн орлого үүсгэгч нэгжийн (цаашид “МОҮН” гэх) дансны үнэ нь нөхөгдөх боломжит тооцоолсон үнээс их байвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрдөг.

Хөрөнгийн эсвэл “МОҮН”-ийн нөхөгдөх үнэ гэдэг нь хөрөнгийн бодит үнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан цэвэр дүн болон хөрөнгийг ашигласнаар олж болох өгөөж хоёрын аль их дүнгээр нь тогтоогддог. Ашигласнаар олж болох өгөөжийг үнэлэхдээ татварын өмнөх дискаунтын хувиар дискаунчилан тооцсон ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг ашигладаг. Хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг дангаар нь шалгах боломжгүй бол тэдгээрийг цаашид ашигласнаар бусад хөрөнгө эсвэл бүлэг хөрөнгөөс “МОҮН” хамааралгүйгээр дангаараа мөнгөн орлого бий болгох чадвартай хамгийн жижиг хөрөнгийн бүлэгт хамааруулан бүлгээр нь үнэ цэнийн бууралтыг үнэлнэ.

Нэгж хөрөнгө эсвэл түүний харъяалагдах “МОҮН”-ийн дансны үнэ нь нөхөгдөх боломжит тооцоолсон үнээс их байвал үнэ цэнийн бууралтын алдагдлыг бүртгэж, дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

Өмнөх тайлант жилүүдэд тодорхойлж бүртгэсэн үнэ цэнийн бууралтын алдагдлыг тайлант жилийн эцсээр эргэн шалгаж, уг алдагдал буурсан эсвэл алдагдалгүй болсон эсэхийг үнэлдэг. Нөхөгдөх боломжтой үнийг тодорхойлохдоо хэрэглэсэн тооцоолол өөрчлөгдсөн бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаадаг. Ингэхдээ хөрөнгийн дансны үнэ тооцвол байх байсан хөрөнгийн дансны үнээс хэтрэхгүй байх хэмжээгээр элэгдэл хорогдлыг хассан цэвэр дүнгээр тооцоолж буцаадаг.

(6) Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь дуусгавар болох хугацаа нь 3 сар болон түүнээс богино хугацаатай бөгөөд бодит үнэ цэнэ өөрчлөгдөх өчүүхэн эрсдэл бүхий бэлэн мөнгө, банкин дахь хугацаагүй хадгаламж болон түргэн хөрвөх чадвартай богино хугацаат хөрөнгө оруулалт (үндсэндээ банкин дахь хугацаат хадгаламж)-аас бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр тайлагнадаг.

(7) Эздийн өмч

Энгийн хувьцааг эздийн өмчид ангилж бүртгэдэг. Шинээр хувьцаа гаргахтай холбоотой зардлыг эздийн өмчийн нэмэгдлийн бууралт байдлаар тайлагнана. Гаргасан нэгж хувьцааны үнэд хүлээн авах бодит үнэ цэнийн нэрлэсэн үнээс илүү гарсан дүнг нэмж төлсөн капиталын өсөлтөөр хүлээн зөвшөөрдөг.

Ногдол ашгийг зөвхөн тухайн тайлант үед эсвэл түүнээс өмнө зарласан бол ногдол ашгийн өр төлбөрөөр бүртгэж, эздийн өмчийг бууруулдаг. Ногдол ашгийг санхүүгийн тайланг батлан гаргахаас өмнө тайлангийн өдрийн байдлаар санал оруулсан эсвэл санал оруулсан ч тайлангийн өдрийн дараагаар зарласан тохиолдолд тодруулдаг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(8) Нөөц

Компанид өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хуулийн эсвэл ёс зүйн) байгаа, компани нь үүргээ барагдуулах шаардлагатай байх магадлалтай, үүргийн дүнг найдвартай тооцоолж болох тохиолдолд нөөцийг хүлээн зөвшөөрнө.

Нөөц болгон хүлээн зөвшөөрсөн дүн нь үүрэгтэй холбоотой эрсдэл, тодорхойгүй байдлыг харгалзан тайлант хугацааны эцэст одоо байгаа үүргийг барагдуулахад шаардагдах төлбөрийн хамгийн сайн тооцоолол юм. Одоогийн өр төлбөрийг барагдуулахаар тооцсон мөнгөн гүйлгээг ашиглан нөөцийг хэмжих үед түүний дансны үнэ нь эдгээр мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнэ юм.

Нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн үр өгөөжийн заримыг эсвэл бүгдийг нь гуравдагч этгээдээс нөхөхөөр хүлээгдэж байгаа тохиолдолд нөхөн төлбөр авах нь бараг тодорхой бөгөөд авлагын дүнг найдвартайгаар хэмжих боломжтой бол авлагыг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.

Нөөцийг тайлант хугацааны эцэст хянаж, одоогийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд тохируулна. Хэрэв өр төлбөрийг барагдуулахын тулд эдийн засгийн үр өгөөжийг шилжүүлэх шаардлагатай болох нь нотлогдоогүй бол уг заалтыг буцаах хэрэгтэй.

(9) Орлого ба зардал хүлээн зөвшөөрөх

Хүүгийн орлого болон зардлыг үр ашигт хүүгийн аргыг ашиглан ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. “Үр ашигт хүү” гэдэг нь хүлээгдэж буй хугацаан дахь ирээдүйд төлөгдөх буюу хүлээн авах мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэглүүрийн дансны үнэд дискаунтчилахад ашиглаж буй хүү юм:

- санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ; эсвэл
- санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртөг.

Худалдан авсан эсвэл үүсгэн бий болгосон, зээлийн үнэлэмж буурсан санхүүгийн хөрөнгөөс бусад санхүүгийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн түвшинг тооцоолохдоо Компани нь санхүүгийн хэрэглүүрийн гэрээний нөхцөлийн дагуу ирээдүйн бүх мөнгөн урсгалыг тооцох боловч хүлээгдэж буй алдагдлыг тооцохгүй. Худалдан авсан эсвэл үүсгэн бий болгосон, зээлийн үнэлэмж буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд зээлийн тохируулсан үр ашигт хүүгийн түвшинг тооцон хүлээгдэж буй алдагдлын ирээдүйн мөнгөн урсгалыг тооцно.

Үр ашигт хүүгийн тооцоололд гүйлгээний зардал, хураамж, төлбөр хийсэн эсвэл хүлээн авсан хугацаа зэрэг үр ашигт хүүгийн чухал хэсгүүд багтана. Гүйлгээний зардалд санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийг худалдан авах болон борлуулахтай шууд хамаарах нэмэгдэл зардал багтана.

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн ‘хорогдуулсан өртөг’ нь санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үндсэн төлөлтийг хасч, үр ашигт хүүгийн түвшинг ашиглан анхны болон эцсийн дүнгийн зөрүүгээр хуримтлагдсан хорогдуулгыг нэмэх эсвэл хасах ба санхүүгийн хөрөнгийн хувьд хүлээгдэж буй аливаа хүлээгдэж буй зээлийн алдагдлын санг тохируулсан дүнг хэлнэ.

Хорогдуулсан өртгөөр хэмжигддэг ‘санхүүгийн хөрөнгийн нийт дансны үнэ’ нь хүлээгдэж буй аливаа зээлийн алдагдлын санг тохируулснаас өмнөх санхүүгийн хөрөнгийн хорогдуулсан өртгийг хэлнэ.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(10) Ажиллагсдын тэтгэмж

(i) Богино хугацаат тэтгэмж

Богино хугацааны ажилтны тэтгэмж гэдэг нь тухайн ажилтны холбогдох үйлчилгээ үзүүлсэн хугацаа дууссанаас хойш 12 сарын дотор төлөх ёстой ажилчдын тэтгэмж юм. Нягтлан бодох бүртгэлийн хугацаанд ажилтан компанид үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд тухайн үйлчилгээнийхээ хариуд төлөхөөр хүлээгдэж буй ажилчдын богино хугацааны тэтгэмжийн дискаунтлаагүй дүнг хүлээн зөвшөөрнө.

(ii) Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл

Монгол улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

(11) Орлогын албан татвар

Орлогын албан татвар нь тайлант хугацааны орлогын албан татварын зардал ба хойшлогдсон татвараас бүрдэнэ. Тайлант хугацааны болон хойшлогдсон татварыг эздийн өмч буюу бусад дэлгэрэнгүй орлогын хэсэгт шууд хүлээн зөвшөөрсөн зүйлсэд хамааралтайгаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

(i) Тайлант хугацааны орлогын албан татвар

Одоогийн болон өмнөх үеүдэд хамааралтай тайлант хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь тайлагналын өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

Эргэлтийн хөрөнгө, өр төлбөр хэсэгт хүлээн зөвшөөрсөн орлогын албан татварын авлага буюу өглөгийг хооронд нь суутган тооцуулахыг хуулиар зөвшөөрсөн бөгөөд Компани хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө бууруулан цэвэр дүнгээр нь барагдуулахаар зэхэж байгаа бол хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр харуулна.

Эздийн өмчийн хэсэгт шууд хүлээн зөвшөөрөх зүйлсэд хамаатай орлогын албан татварыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрөхгүй. Удирдлага нь нягтлан бодох бүртгэлийг яаж хөтлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахаар тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

(ii) Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварыг хөрөнгө, өр төлбөрийн аргыг ашиглан хүлээн зөвшөөрч бүртгэдэг бөгөөд энэ арга нь санхүүгийн тайлангийн зорилгоорх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон татварын зорилгоор ашиглагдах дүн хоёрын хоорондох түр зөрүүн дээр үндэслэдэг. Бүх татвар ногдох түр зөрүүнд хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийг татвар ногдох орлого олсон үед татварын орлого ногдох нь тодорхой болсон бүх хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө.

Дараах түр зөрүүнүүдэд хойшлогдсон татварыг хүлээн зөвшөөрдөггүй: гүүдвилийн анхдагч хүлээн зөвшөөрөлт, эсвэл бизнесийн нэгдэл биш бөгөөд ажил гүйлгээ гарах үед нягтлан бодох бүртгэлийн ашиг болон татвар ногдох ашиг/татварын алдагдлын аль алинд нөлөөлөхгүй ажил гүйлгээн дэх хөрөнгө буюу өр төлбөрийн анхдагч хүлээн зөвшөөрөлт.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(11) Орлогын албан татвар, үргэлжлэл

(ii) Хойшлогдсон татвар, үргэлжлэл

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант хугацааны эцэс бүрд дахин хянаж үздэг ба хойшлогдсон татварын хөрөнгийн бүх эсвэл зарим өгөөжийг хүртэх хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлалгүй болох үед Компани хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

Тайлант үеийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөж байгаа татварын хувь хэмжээ (татварын хууль)-нд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу өр төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийг хэмждэг. Тайлант үеийн эцэст Компани нь хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг нөхөх буюу барагдуулах арга хэлбэрээс үүсэж байгаа татварын үр нөлөөг хойшлогдсон татварын өр төлбөр болон хойшлогдсон татварын хөрөнгийн хэмжилтэд тусгадаг.

Компани нь тайлант үеийн татварын өр төлбөрийг тайлант үеийн татварын хөрөнгөөр суутган тооцох хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй байх, орлогын татвараар тооцоо хийдэг ижил татварын албатай харьцдаг ба тайлант үеийн татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр сууриар барагдуулахаар төлөвлөсөн тохиолдолд хойшлогдсон татварын өр төлбөр болон хөрөнгийг цэвэр дүнгээр тооцдог.

Хэрэв ногдол ашиг төлөлттэй холбоотойгоор нэмэлт орлогын албан татварын зардал үүссэн бол уг орлогын албан татварын зардлыг ногдол ашгийн төлөлттэй холбоотой өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх үед орлогын албан татварын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

(12) Түрээс

(i) Түрээслэгчийн хувьд

Гэрээг анх байгуулах үед Компани нь тухайн гэрээ нь түрээсийн гэрээ юу эсвэл түрээс агуулсан гэрээ эсэхийг үнэлдэг. Хэрэв гэрээ нь тодорхой төлбөр хүлээн авснаар тухайлсан хөрөнгийн хэрэглээг тодорхой хугацаанд хянах эрхийг олгож байвал тухайн гэрээ нь түрээсийн гэрээ эсвэл түрээс агуулсан гэрээ гэж үзнэ. Гэрээ нь тодорхой хөрөнгийн ашиглалтыг хянах эрхийг хангаж байгаа эсэхийг үнэлэхийн тулд компани СТОУС 16-д заасан түрээсийн тодорхойлолтыг ашигладаг.

Түрээсийн бүрэлдэхүүн агуулсан гэрээг эхлэх эсвэл өөрчлөх үед Компани гэрээнд тусгасан үнийг үндэслэн түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт хуваарилдаг боловч хөрөнгийн түрээсийн хувьд Компани нь түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг салгах аргыг сонгосон ба харин түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг бүрэлдэхүүн хэсэг гэж бүртгэдэг.

Компани нь түрээс эхлэх өдөр ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг. Ашиглах эрхтэй хөрөнгийг анх өртгөөр нь хэмжих бөгөөд үүнийг түрээсийн эхний өдөр болон түүнээс өмнө хийсэн түрээсийн төлбөрөөр тохируулсан түрээсийн өр төлбөрийн анхны дүн, аливаа анхдагч шууд зардлууд болон хөрөнгийг салгаж буулгах, сэргээн засварлахад түрээслэгчээс гарах аливаа тооцоолсон болон түрээсийн урамшууллыг хассан дүнгээр илэрхийлдэг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(12) Түрээс, үргэлжлэл

(i) Түрээслэгчийн хувьд, үргэлжлэл

Түрээсийн хугацаа дуусгавар болох үед ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг нь худалдан авах сонголтыг тусгасан эсвэл үндсэн түрээсийн хөрөнгийг өмчлөх эрх Компанид бүрэн шилжихээс бусад үед ашиглах эрхтэй хөрөнгийг гэрээ эхэлсэн өдрөөс дуусах өдөр хүртэл шулуун шугамын аргаар элэгдүүлнэ. Энэ тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийг тухайн хөрөнгийн ашиглалтын жилээр элэгдүүлэх бөгөөд ашиглалтын жилийг үндсэн хөрөнгийн ашиглалтын жилийг тодорхойлох сууриар тодорхойлдог. Түүнчлэн, ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнийг аливаа үнэ цэнийн бууралтын алдагдлаар бууруулж, түрээсийн өр төлбөрийн дахин хэмжилтээр тохируулдаг.

Түрээсийн өр төлбөрийг анх хэмжихдээ түрээсийн эхний өдрөөрх төлөгдөөгүй түрээсийн төлбөрүүдийг түрээст агуулагдсан нуугдмал хүүгийн хувь хэмжээ эсвэл уг хувь хэмжээг тодорхойлох боломжгүй бол Компанийн өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг ашиглан дискаунталсан өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

Компани нь өсөн нэмэгдэх зээлийн хүүгийн хувь хэмжээг хэд хэдэн хөндлөнгийн санхүүгийн эх үүсвэрээс хүүгийн хувь хэмжээг авах замаар тодорхойлдог бөгөөд түрээсийн нөхцөл, түрээсэлсэн хөрөнгийн төрлийг илэрхийлэх тодорхой тохируулгуудыг хийдэг.

Түрээсийн өр төлбөрийн хэмжилтэд багтсан түрээсийн төлбөрт дараах зүйлүүд багтана:

- тогтмол төлбөр, түүний дотор материаллаг тогтмол төлбөр;
- индекс эсвэл хувь хэмжээнээс хамаарах хувьсах түрээсийн төлбөр, эхний өдөр индекс эсвэл хувь хэмжээг ашиглан хэмжсэн анхны хэмжилтээр
- үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүнд
- Компанийн худалдан авах сонголтоо хэрэгжүүлэх нь үндэслэлтэйгээр тодорхой бол уг сонголтыг хэрэгжүүлэх үнэ. Үүнд Компани түрээсийг сунгана гэж үзвэл сунгалтын нэмэлт төлбөр, түрээсийн хугацааг эрт цуцлах торгууль.

Түрээсийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хэрэв индекс эсвэл хувь хэмжээнээс шалтгаалан Компанийн ирээдүйн түрээсийн төлбөр өөрчлөгдөх, үлдэх өртгийн үнэ цэнийн баталгааны хүрээнд хүлээгдэж буй өглөгийн дүнд өөрчлөлт орсон тохиолдолд худалдан авалт хийх, сунгах эсвэл цуцлах эсэхэд өөрчлөлт орсон эсвэл үндсэн түрээсийн төлбөрийг шинэчилсэн тохиолдолд дахин хэмждэг.

Түрээсийн өр төлбөрийг ийм байдлаар дахин хэмжихэд ашиглах эрхтэй хөрөнгийн дансанд холбогдох тохируулгыг хийх ба хэрэв ашиглах эрхтэй хөрөнгийн дансны үнэ тэг болж буурсан тохиолдолд ашиг, алдагдал бүртгэдэг.

Компани нь санхүүгийн байдлын тайланд хөрөнгө оруулалтын зорилгоорх үл хөдлөх хөрөнгийн тодорхойлолтыг хангаагүй ашиглах эрхтэй хөрөнгийг 'үндсэн хөрөнгө'-ийн ангилалд, түрээсийн өр төлбөрийг 'зээл ба өр төлбөр'-ийн ангилалд бүртгэдэг.

Богино хугацааны түрээс, бага өртөг бүхий түрээс

Компани бага үнэтэй хөрөнгийн түрээс болон богино хугацаат түрээсийн (үүнд оффисын түрээс багтана) хувьд ашиглах эрхтэй хөрөнгө болон түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй байх аргыг сонгосон. Компани эдгээр түрээстэй холбоотой түрээсийн төлбөрүүдийг түрээсийн хугацааны турш шулуун шугамын аргаар зардлаар хүлээн зөвшөөрдөг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(12) Түрээс, үргэлжлэл

(ii) Түрээслүүлэгчийн хувьд

Түрээсийн бүрэлдэхүүн хэсэг агуулсан гэрээг анх хэрэгжиж эхлэх эсвэл өөрчлөлт орсон үед Компани нь гэрээнд тусгасан үнийг түрээсийн бүрэлдэхүүн хэсэг бүрт тэдгээрийн тус бүрийн үнэнд суурилан хуваарилна.

Компани нь түрээслүүлэгчийн хувьд, гэрээний эхэнд тухайн түрээсийг санхүүгийн эсвэл үйл ажиллагааны түрээсийн аль болохыг тодорхойлно.

Түрээсийн ангиллыг тодорхойлохдоо Компани нь тухайн хөрөнгийг эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл болон өгөөжийн бараг бүгдийг нь шилжүүлсэн эсэхийг ерөнхий үнэлгээгээр шалгадаг. Хэрвээ шилжсэн бол тухайн түрээсийг санхүүгийн түрээс, шилжээгүй бол үйл ажиллагааны түрээс гэж ангилна. Энэхүү үнэлгээнд Компани нь хөрөнгийг эдийн засгийн ашиглах хугацааны ихээхэн хэсэгт түрээслүүлж буй эсэх зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үздэг.

Хэрвээ гэрээ нь түрээсийн болон түрээсийн бус бүрэлдэхүүн хэсгүүдийг агуулсан байвал Компани нь гэрээний үнийг хуваарилахдаа СТОУС 15-ыг мөрддөг.

Компани нь түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтанд СТОУС 9-ийн үл хүлээн зөвшөөрөлт ба үнэ цэнийн бууралтын шалгууруудыг хэрэгжүүлдэг. Компани нь түрээсийн нийт хөрөнгө оруулалыг тооцоолоход ашигласан баталгаагүй үлдэгдэл үнэ цэнийг тогтмол хянаж байдаг.

Компани нь үйл ажиллагааны түрээсийн орлогод хүлээн авсан түрээсийн төлбөрийг түрээсийн хугацааны туршид шулуун шугамын аргаар “бусад орлого”-оор хүлээн зөвшөөрдөг.

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(13) Холбоотой талууд

- (i) Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд Компанитай холбоотой гэж үзнэ.
- компанийг шууд эсвэл хамтран хянадаг;
 - компанийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг;
 - компанийн болон Компанийн толгой компанийн удирдах ажилтан.
- (ii) Хэрэв дараах нөхцөлийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгжийг Компанитай холбоотой гэж үзнэ:
- тухайн аж ахуйн нэгж болон Компани нь нэг бүлэг аж ахуйн нэгжийн бүрэлдэхүүнд багтаж байвал өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид багтдаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой гэсэн үг юм;
 - нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтарсан үйлдвэр бол;
 - хоёр компани хоёулаа нэг гуравдагч этгээдийн хамтарсан хөрөнгө оруулалттай компани бол;
 - нэг аж ахуйн нэгж нь гуравдагч аж ахуйн нэгжийн хамтарсан үйлдвэр ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч аж ахуйн нэгжийн хараат компани бол;
 - тухайн аж ахуйн нэгж нь дээр дурьдсан холбоотой талаар тодорхойлогдсон хувь хүний шууд эсвэл хамтарсан хяналтан доор байх;
 - Компанийг шууд эсвэл хамтран хянадаг этгээд нь тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд их хэмжээний нөлөөтэй байх, тухайн аж ахуйн нэгжийн, эсвэл түүний толгой компанийн удирдах ажилтан

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь Компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж магадгүй гэр бүлийн гишүүдийг хэлнэ.

4. Шинэ буюу шинэчилсэн стандарт (СТОУС-ууд) болон тайлбар тодруулгуудын хэрэгжилт

Компани нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн СТОУС-ын өөрчлөлтүүдийг тайлант жилд хэрэгжүүлсэн.

Хэрэгжиж эхэлсэн буюу эхлэх хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2022 оны 01 дүгээр сарын 01	<ul style="list-style-type: none">• НББОУС 37-ийн нэмэлт өөрчлөлт Алдагдалтай гэрээ – Гэрээний биелэлтийн өртөг• 2018-2020 оны СТОУС-ын жилийн сайжруулалтын өөрчлөлтүүд• НББОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт Үндсэн хөрөнгө: Ашиглахаас өмнөх хөрөнгийн орлого• СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт Үзэл баримтлалын тайлбар

Шинэчлэгдсэн СТОУС-ын стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд нь Компанийн санхүүгийн байдал болон гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн тодруулгуудад материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

5. Мөрдөгдөж эхлээгүй байгаа батлагдсан СТОУС-ын шинэчилсэн стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд

Компанийн санхүүгийн тайланг батлан гаргах үед батлагдсан байсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон тайлбаруудыг дор тодруулсан болно. Компани эдгээрийг хэрэгжиж эхэлсэн үеэс дагаж мөрдөнө.

Хэрэгжиж эхэлсэн буюу эхлэх хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2023 оны 01 дүгээр сарын 01	<ul style="list-style-type: none"> • СТОУС 17 Даатгалын гэрээ • НББОУС 1 ба СТОУС-ийн практик мэдэгдлийн 2-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тодруулах нь
2023 оны 01 дүгээр сарын 01	<ul style="list-style-type: none"> • НББОУС 8-ийн нэмэлт өөрчлөлт - Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт • НББОУС 12-ийн нэмэлт өөрчлөлт - Нэг удаагийн ажил гүйлгээнээс үүссэн хөрөнгө, өр төлбөрт хамаарах хойшлогдсон татвар • СТОУС 17 ба СТОУС 9-ийн анхны хэрэгжүүлэлт - Харьцуулагдах мэдээлэл (СТОУС 17-ийн нэмэлт өөрчлөлт)
2024 оны 01 дүгээр сарын 01	<ul style="list-style-type: none"> • Борлуулаад буцаан түрээслэх ажил гүйлгээний түрээсийн өр төлбөр (СТОУС 16-ийн нэмэлт өөрчлөлт) • НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт Эргэлтийн ба Эргэлтийн бус өр төлбөрийн ангилал
Сонголтоор хэрэгжүүлэх боломжтой/ хүчин төгөлдөр болох огноог тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан	<ul style="list-style-type: none"> • СТОУС 10 болон НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт - Хөрөнгө оруулагч болон хараат эсвэл хамтарсан компанийн хөрөнгийн борлуулалт эсвэл худалдах үнэ

Компани нь санхүүгийн тайланд эдгээр стандартын нэмэлт өөрчлөлтүүд томоохон нөлөө үзүүлэхгүй гэсэн хүлээлттэй байна.

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

6. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Бэлэн мөнгө	1,905	1,006
Харилцах данс	<u>47,608,642</u>	<u>9,937,352</u>
	<u>47,610,547</u>	<u>9,938,358</u>

Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь богино хугацаатай, хөрвөх чадвар сайтай хөрөнгө бөгөөд бэлэн мөнгө рүү түргэн хөрвөх чадвартай, үнэ цэнээ алдах эрсдэл багатай байдгаараа онцлог юм. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг барьцаагаар хангах шаардлагагүй бөгөөд хугацааны болон үнэ цэнийн бууралт тооцох үзүүлэлтээр ангилах шаардлагагүй байдаг.

Мөнгөтэй адилтгах хөрөнгийн эрсдэлийг Мүүдийзийн зэрэглэлээр үнэлсэн. 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
ВЗ	47,608,642	9,937,352

Үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
01 дүгээр сарын 01-ний өдрөөр	-	(663)
Үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	-	<u>663</u>
12 дугаар сарын 31-ний өдрөөр	<u>-</u>	<u>-</u>

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

7. Хугацаатай хадгаламж

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Хугацаатай хадгаламж	-	36,709,010
Хуримтлагдсан хүүгийн авлага	-	510,735
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	-	(9,245,373)
	<u>-</u>	<u>27,974,372</u>

Хугацаатай хадгаламжийн эрсдэлийг Мүүдийзийн зэрэглэлээр үнэлсэн. 12 дугаар сарын 31-ний өдрөөрх зээлжих зэрэглэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
ВЗ	-	28,114,947
Зэрэглэлгүй	-	9,104,798
	<u>-</u>	<u>37,219,745</u>

Үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
01 дүгээр сарын 01-ний өдрөөр	(9,245,373)	(8,952,102)
Хугацаатай хадгаламжийн үнэ цэнийн бууралтын алдагдал	(151,757)	(293,271)
Үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	232,040	-
Шилжүүлэг*	9,165,090	-
12 дугаар сарын 31-ний өдрөөр	<u>-</u>	<u>(9,245,373)</u>

*Компани нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Чингис Хаан Банкнд 9,230,646 мянган төгрөгийн үлдэгдэл бүхий харилцах данстай бөгөөд уг дансанд 9,165,090 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын сан байгуулсан байсан. Шүүхийн 2022 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн хуралдааны дагуу тус Компанид Чингис хаан банкнаас 9,348,919 мянган төгрөгийг гаргуулахаар шийдвэрлэсэн ба Компани уг дүнг 2022 онд авлага дансанд дахин ангилсан.

8. Дансны болон бусад авлага

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Дансны авлага	2,919	2,130
Ажилчдаас авах авлага	330	16
Бусад авлага	9,351,175	-
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(9,165,090)	-
	<u>189,334</u>	<u>2,146</u>

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

9. Түрээсийн авлага

(Мянган төгрөгөөр)	2022	2021
Түрээсийн авлага	67,843,100	70,575,914
Хуримтлагдсан хүү болон торгуулийн хүүгийн авлага	15,968,603	9,673,643
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(16,696,432)	(9,104,516)
	67,115,271	71,145,041

Тайлангийн өдрөөрх түрээсээрх нийт хөрөнгө оруулалтын дүн ба түрээсийн цэвэр хөрөнгө оруулалтын уялдааг Тодруулга 23-аас харна уу.

Түрээсийн авлагын насжилт дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2022		2021	
	Түрээсийн авлага	Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	Түрээсийн авлага	Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан
Хэвийн	1,726,368	(7)	9,343,864	(443,852)
Хугацаа хэтэрсэн хоног				
1-30 хоног	4,213,823	-	-	-
31-90 хоног	-	-	-	-
91-180 хоног	919,945	(829)	259,628	(41,649)
181-360 хоног	367,318	-	22,577,403	(3,523,738)
361-ээс дээш хоног	76,584,249	(16,695,596)	48,068,662	(5,095,277)
	83,811,703	(16,696,432)	80,249,557	(9,104,516)

Үнэ цэнийн бууралтын алдагдлын сангийн хөдөлгөөн дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2022	2021
01 дүгээр сарын 01-ний өдрөөр	(9,104,516)	(5,916,794)
Тайлант жилд нэмэгдсэн	(12,799,138)	(3,411,644)
Үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	5,207,222	223,922
12 дугаар сарын 31-ний өдрөөр	(16,696,432)	(9,104,516)

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

10. Үндсэн хөрөнгө

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Тээврийн хэрэгсэл</u>	<u>Ашиглах эрхтэй хөрөнгө</u>	<u>Компьютер</u>	<u>Тавилга эд хогшил</u>	<u>Нийт</u>
Өртөг					
2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	26,907	157,000	125,722	89,094	398,723
Нэмэгдсэн	-	-	3,654	-	3,654
Данснаас хассан	-	-	-	(4,202)	(4,202)
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	26,907	157,000	129,376	84,892	398,175
Хуримтлагдсан элэгдэл					
2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	26,907	54,756	115,996	36,011	233,670
Тайлант жилд байгуулсан	-	15,700	8,588	8,436	32,724
Данснаас хассан	-	-	-	(1,876)	(1,876)
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	26,907	70,456	124,584	42,571	264,518
Цэвэр дансны үнэ	-	86,544	4,792	42,321	133,657
<i>(Мянган төгрөгөөр)</i>					
Өртөг					
2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	26,907	157,000	120,716	89,094	393,717
Нэмэгдсэн	-	-	5,006	-	5,006
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	26,907	157,000	125,722	89,094	398,723
Хуримтлагдсан элэгдэл					
2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр	21,656	39,056	94,196	26,583	181,491
Тайлант жилд байгуулсан	5,251	15,700	21,800	9,428	52,179
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр	26,907	54,756	115,996	36,011	233,670
Цэвэр дансны үнэ	-	102,244	9,726	53,083	165,053

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

11. Дансны болон бусад өглөг

(Мянган төгрөгөөр)	2022	2021
Дансны өглөг	260,326	168,420
Суутган татварын өглөг	3,866	68,284
Буцаан олголтын тооцоо	5,567	731,632
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	-	1,656
	269,759	969,992

12. Түрээсийн өр төлбөр

12 дугаар сарын 31-ний өдрөөрх түрээсийн өр төлбөр дараах байдалтай байна:

Зээлдүүлэгч	Валют	Хүүгийн түвшин	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2022 (Мянган төгрөгөөр)	
					Богино хугацаат	Урт хугацаат
Хаан банк	Төгрөг	15%	2018.07.10	2023.07.23	20,587	-

Зээлдүүлэгч	Валют	Хүүгийн түвшин	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2021 (Мянган төгрөгөөр)	
					Богино хугацаат	Урт хугацаат
Хаан банк	Төгрөг	15%	2018.07.10	2023.07.23	34,840	20,801

13. Зээл

(Мянган төгрөгөөр)	2022	2021
Богино хугацаат зээл	-	7,046,442
Хуримтлагдсан хүүгийн өглөг	-	111,199
	-	7,157,641

(1) Богино хугацаат зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна:

Зээлдүүлэгч	Валют	Хүүгийн түвшин	Эхэлсэн огноо	Дуусах огноо	2022 Мян.төг	2021 Мян.төг
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК	Ам доллар	3.6%	2017.07.28	2022.07.28	-	7,046,442

(2) Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн зээлийн өр төлбөрийн хөдөлгөөн:

(Мянган төгрөгөөр)	2022	2021
01 дүгээр сарын 01-ний өдрөөр	7,046,442	18,945,808
Зээлийн эргэн төлөлт	(7,076,856)	(11,927,028)
Гадаад валютын ханшийн зөрүү	30,414	27,662
12 дугаар сарын 31-ний өдрөөр	-	7,046,442

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

14. Хувьцаат капитал

	Энгийн хувьцааны тоо		2022	2021
	2022	2021	мян.төг	мян.төг
01 дүгээр сарын 01-ний өдөр	2,000,000	2,000,000	100,000,000	100,000,000
Тайлант жилийн өөрчлөлт*	(1,900,000)	-	-	-
12 дугаар сарын 31-ний өдөр	100,000	2,000,000	100,000,000	100,000,000

* 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу Компанийн дүрмийг шинэчилсэн. Компанийн шинэчлэгдсэн дүрмийн дагуу 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нэгж нь 1,000 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 100 мянган ширхэг, нийт 100,000,000 мянган төгрөгийн хувьцаатай байсан. 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэгж нь 50 мянган төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,000 мянган ширхэг хувьцаанаас бүрдэж байсан.

15. Хүүгийн орлого

(Мянган төгрөгөөр)	2022	2021
Түрээсийн авлага	14,045,872	9,560,848
Хугацаатай хадгаламж	1,613,114	623,905
Харилцах данс	-	278,542
	15,658,986	10,463,295

16. Хүүгийн зардал

(Мянган төгрөгөөр)	2022	2021
Зээл	22,202	454,857
Түрээсийн өр төлбөр	5,746	10,601
	27,948	465,458

17. Үйл ажиллагааны зардал

(Мянган төгрөгөөр)	2022	2021
Цалингийн зардал	269,286	694,030
Нийгмийн даатгал шимтгэлийн зардал	34,625	90,733
Богино хугацаат түрээсийн зардал	82,027	86,198
Албан томилолтын зардал	41,033	4,517
Элэгдэл болон хорогдол	33,777	53,099
Тээвэр ба шатахууны зардал	6,392	2,039
Бусад зардал	195,380	118,968
	662,520	1,049,584

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

18. Бусад орлого/ (зардал), цэвэр

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Гадаад валютын ханшийн хөрвүүлэлтийн хэрэгжсэн олз, цэвэр	291,754	27,428
Ханшийн тэгшитгэлийн хэрэгжээгүй (олз)/ гарз, цэвэр	7,622,082	(3,210,139)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз	1,510	-
Бусад зардал/ (орлого)	<u>(1,481)</u>	<u>62</u>
	<u>7,913,865</u>	<u>(3,182,649)</u>

19. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдал

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын алдагдал	12,799,138	3,411,644
Түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	(5,207,222)	(223,922)
Хугацаатай хадгаламжийн үнэ цэнийн бууралтын алдагдал	151,757	293,271
Хугацаатай хадгаламжийн үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	(232,040)	-
Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	-	(663)
	<u>7,511,633</u>	<u>3,480,330</u>

20. Орлогын татварын зардал

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Тайлант жилийн татварын зардал	2,737,127	1,213,727
Хойшлогдсон татварын зардал	582,074	-
	<u>3,319,201</u>	<u>1,213,727</u>

(i) Татварын өмнөх орлогоос татварын үр ашигт хувь хэмжээгээр тооцоолсон орлогын татварын зардлыг дараах байдлаар тооцоолно:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Татварын өмнөх ашиг	15,370,750	2,285,274
Нийтлэг хувь хэмжээгээр тооцсон татвар (*)	2,942,688	228,527
Хасагдахгүй зардлын татварын нөлөө	1,475,801	894,955
Татвар ногдохгүй орлогын татварын нөлөө	(1,260,599)	-
Тусгай хувь хэмжээгээрх татвар	161,311	90,245
	<u>3,319,201</u>	<u>1,213,727</u>

20. Орлогын татварын зардал, үргэлжлэл

(*) Компани нь Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу 6 тэрбум хүртэлх татвар ногдуулах орлогод 10 хувь, 6 тэрбум төгрөгөөс давсан татвар ногдуулах орлогод 25 хувийн татвар ногдуулна.

Монгол Улсын Засгийн газар зах зээлийн эдийн засагт шилжихдээ бизнес, худалдааны дэд бүтцийн шинэчлэлийг үргэлжлүүлж байна. Үүний үр дүнд бизнест нөлөөлж буй хууль, тогтоомжууд хурдацтай өөрчлөгдсөөр байгаа бөгөөд эдгээр өөрчлөлтүүд нь заримдаа хуулийн төсөл зохисгүй байх, янз бүрээр тайлбарлах, татварын албаныхан зөрчилтэй хэрэглэх зэргээр тодорхойлогддог. Тодруулбал, татварыг хуулийн дагуу торгууль, шийтгэл оногдуулах эрхтэй хэд хэдэн эрх бүхий байгууллага хянаж, шалгадаг. Тайлант хугацааны эцэст татварын хууль тогтоомжын талаарх ойлголтдоо үндэслэн бүх татварын өр төлбөрийг зохих ёсоор хангасан гэж компани үзэж болох боловч дээрх баримтууд нь компанийн хувьд татварын эрсдэлийг үүсгэж болзошгүй бөгөөд энэ үе шатанд тоон үзүүлэлтийг гаргах боломжгүй юм.

Компани нь биелэгдээгүй гадаад валютын ханшийн зөрүүний ашиг, алдагдлаас үүссэн түр зөрүүг хойшлуулсан татварын өр төлбөр гэж хүлээн зөвшөөрсөн. Хойшлогдсон татварын өр төлбөрийн өөрчлөлтийг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хуримтлагдсан түр зөрүүний өөрчлөлт дараах байдалтай байна:

	<u>2022.01.01</u>	<u>Түр зөрүүний өөрчлөлт</u>	<u>2022.12.31</u>
Хойшлогдсон татварын өр	82,341	582,074	664,415

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хуримтлагдсан түр зөрүүний өөрчлөлт дараах байдалтай байна:

	<u>2021.01.01</u>	<u>Түр зөрүүний өөрчлөлт</u>	<u>2021.12.31</u>
Хойшлогдсон татварын өр	82,341	-	82,341

21. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ болон үлдэгдэл

(i) Холбоотой талуудын харилцан хамаарал

Дараах байгууллагууд нь Компанийн холбоотой талууд болно.

<u>Байгууллагын нэр</u>	<u>Харилцан хамаарал</u>
Монгол Улсын Засгийн Газар (МУЗГ)	Дээд шатны хяналт тавих байгууллага
Сангийн яам (СЯ)	Дунд шатны хяналт тавих байгууллага
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК (МУХБ)	Толгой компани
Ди Би Эм Ассет Менежмент ҮЦК ХХК	Зэргэлдээ компани
Төрийн Банк ХК	МУ-ын ЗГ-ын нэгдсэн хяналттай байгууллага
Бусад Засгийн газрын байгууллагууд	МУ-ын ЗГ-ын нэгдсэн хяналттай байгууллага

(ii) Холбоотой талуудын үлдэгдэл

(Мянган төгрөгөөр)

	<u>2022.12.31</u>	<u>2021.12.31</u>
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:		
Харилцах данс	30,591,055	8,188,403
Зээл	-	(7,046,442)
Зээлийн хуримтлагдсан хүүгийн өглөг	-	(111,199)
Төрийн Банк ХК:		
Харилцах данс	16,591,309	1,631,178
Хугацаатай хадгаламж	-	11,822,044
Хүүгийн авлага	-	204,990
Бусад Засгийн газрын байгууллагууд:		
Дансны болон бусад өглөг	-	8,209
Түрээсийн авлага	47,104,158	41,563,801
Хуримтлагдсан хүү болон торгуулийн хүүгийн авлага	9,915,568	4,011,222
Түрээсийн авлагын үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(1,011,193)	(4,508,214)

21. Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ, үргэлжлэл

(iii) Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Монгол Улсын Хөгжлийн Банк ХХК:		
Зээлийн хүүгийн зардал	(22,202)	(454,270)
Бусад орлого	-	16
Сангийн Яам:		
Зээлийн хүүгийн зардал	-	(587)
Төрийн Банк ХК:		
Харилцах дансны хүүгийн орлого	-	38,450
Хугацаатай хадгаламжийн хүүгийн орлого	1,423,533	204,990
Бусад засгийн газрын байгууллагууд:		
Түрээсийн хүүгийн орлого	1,439,252	2,082,168
Түрээсийн торгуулийн хүүгийн орлого	802,589	1,856,101

(iv) Удирдлагын гол ажилтнуудын цалин, урамшуулал

Удирдах гол албан тушаалтнууд нь Гүйцэтгэх Захирал болон Захирлуудын Зөвлөл юм. Захирлууд болон бусад удирдлагын голлох ажилтнуудын тайлант үеийн цалин, урамшуулал дараах байдалтай байна.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Цалин урамшуулал	91,651	19,105
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	11,451	2,388
	<u>103,102</u>	<u>21,493</u>

Удирдах гол албан тушаалтнуудын цалин урамшуулал нь цалин болон ажил олгогчоос төлсөн эрүүл мэнд, нийгмийн даатгалаас бүрдэнэ.

22. Санхүүгийн түрээс

Түрээслэгчийн хувьд

Компани нь тээврийн хэрэгслийг 60 сарын хугацаатай түрээслэсэн. Компанийн түрээслэгч байх түрээсийн талаарх мэдээллийг доор харуулав:

(а) Ашиглах эрхтэй хөрөнгө

Түрээстэй холбоотой ашиглах эрхтэй хөрөнгө нь үндсэн хөрөнгөнд толилуулагдсан болно.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
01 дугаар сарын 01-ний үлдэгдэл	102,244	117,944
Тайлант жилд байгуулсан элэгдэл	(15,700)	(15,700)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>86,544</u>	<u>102,244</u>

(б) Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүн

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Тайлант жилд байгуулсан элэгдэл	15,700	15,700
Санхүүгийн түрээсийн хүү	5,746	10,601

(в) Мөнгөн гүйлгээний тайланд хүлээн зөвшөөрөгдсөн дүн

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
Түрээсийн мөнгөн хөрөнгийн гарах урсгал	(40,800)	(40,801)

(г) Санхүүгийн үйл ажиллагаанаас үүссэн түрээсийн өр төлбөрийн хөдөлгөөн

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2022</u>	<u>2021</u>
01 дугаар сарын 01-ний үлдэгдэл	55,641	85,841
Түрээсийн өр төлбөрийн хүү	5,746	10,601
Түрээсийн төлбөр	(40,800)	(40,801)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>20,587</u>	<u>55,641</u>

23. Түрээслүүлэгчийн хувьд санхүүгийн түрээс

Тайлагналын өдрөөс хойш хүлээн авах дискаунтчилаагүй түрээсийн төлбөрийг дуусах хугацаагаар ангилан дараах хүснэгтээр харуулбал:

(Мянган төгрөгөөр)	2022.12.31	2021.12.31
Санхүүгийн түрээсийн авлагын нийт хөрөнгө оруулалт		
Нэг жилээс бага	83,056,131	71,417,484
Нэгээс хоёр жил	3,177,644	10,434,985
Хоёроос гурван жил	2,105,958	3,016,998
Гурваас дөрвөн жил	1,888,081	2,460,672
Дөрвөөс таван жил	1,586,535	1,957,177
Таваас дээш жил	1,199,054	2,981,196
Нийт түрээсийн авлагын дискаунтчилаагүй дүн	93,013,403	92,268,512
Хойшлогдсон санхүүгийн орлого	(9,201,700)	(12,018,955)
Түрээсийн цэвэр хөрөнгө оруулалт	83,811,703	80,249,557

24. Эрсдэлийн удирдлага

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани санхүүгийн хэрэглүүрийг ашигласнаас үүдэн дараах төрлийн эрсдэлүүдэд өртөж байдаг:

- Зээлийн эрсдэл
- Зах зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл

Энэхүү тодруулга нь дээрх эрсдэл тус бүрийн Компанид нөлөөлөх нөлөөлөл, уг эрсдэлийг тооцоолох, удирдах Компанийн зорилго, бодлого, авах арга хэмжээ, мөн Компанийн капиталын удирдлагын талаарх мэдээллийг агуулсан.

Хувьцаа эзэмшигч нь Компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бий болгох, түүнийг хянах ерөнхий үүрэг хариуцлагыг хүлээж байдаг.

1) Зээлийн эрсдэл

Компанийн эрсдэлийн удирдлагын бодлого нь Компанид тулгарч буй эрсдэлүүдийг тодорхойлох, шинжлэх, тохиромжтой эрсдэлийн хязгаар, хяналтыг бий болгох, эрсдэлийг хянах, хязгаарыг мөрдөхөд чиглэгдсэн байдаг. Эрсдэлийн удирдлагын бодлого болон системийг зах зээлийн нөхцөл байдал болон Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа өөрчлөлтүүдийг тусгахын тулд тогтмол хянаж байдаг.

Компани нь ажилчдад тэдний үүрэг болон хариуцлагыг ухамсарлуулж чадахуйц дэг журамтай, үр дүнтэй хяналтын орчинг өөрийн сургалт болон удирдлагын стандарт, горимуудыг хэрэгжүүлэх замаар бий болгохыг зорьж ажилладаг.

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс Компанид санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл бөгөөд энэ нь голдуу үйлчлүүлэгчдээс авах Компанийн авлагаас үүдэлтэй байдаг.

Компанийн зээлийн эрсдэл нь юун түрүүнд банкна дах бэлэн мөнгө, дансны болон бусад авлагатай холбоотой байдаг. Удирдлага нь эдгээр зээлийн эрсдэлд тогтмол хяналт тавьдаг.

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Компанийн удирдлага нь зээлийн эрсдэл багатай гэж үнэлсэн нэр хүнд бүхий банкуудад мөнгөн хөрөнгөө байршуулдаг.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдэлийг илэрхийлж байдаг.

12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн хөрөнгийн хамгийн их хүлээх зээлийн эрсдэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	2022.12.31	2021.12.31
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	47,608,642	9,937,352
Хугацаатай хадгаламж	-	27,974,372
Дансны болон бусад авлага	189,334	2,146
Түрээсийн авлага	67,115,271	71,145,041
	114,913,247	109,058,911

Мөнгөн түүнтэй адилтгах хөрөнгө болон хугацаатай хадгаламж

Компанийн төлөгдөх байдлын эрсдэлд өртөх байдал нь гол төлөв Компанийн хадгаламж байршуулсан банкуудын онцлог шинж чанараас хамаардаг. Компанийн удирдлага нь зээлийн бодлогыг бий болгосон бөгөөд үүний дагуу банк тус бүрийг зээлийн чадварт нь тус тусад нь дүн шинжилгээ хийдэг.

Компанийн үнэлгээнд гадны үнэлгээ, хэрэв боломжтой бол санхүүгийн тайлангууд, зээлийн зэрэглэл тогтоох байгууллагын мэдээлэл, салбарын мэдээлэл болон зарим тохиолдолд Монголбанкны лавлагаа орно. Компани нь Монгол Улсын эдийн засгийн орчин, банкны салбарыг ажиглаж, эдийн засгийн нөхцөл байдалд аливаа хүндрэл үүсэх тохиолдолд үүсч болох эрсдэлийг хязгаарлах бодлого баримталдаг.

Түрээсийн авлага

Компанийн түрээсийн авлагын эрсдэл нь голдуу худалдан авагч тус бүрийн хувийн онцлогоос хамааралтай байдаг. Удирдлага нь түрээсийн авлагын эрсдэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс болох харилцагчдын үйл ажиллагаагаа явуулж буй улс орон болон тухайн салбарын төлбөр гүйцэтгэх чадваргүй болох эрсдэл зэрэг Компанийн харилцагчдын онцлогыг харгалзан үздэг.

Компанийн стандарт нөхцлийг харилцагчдад санал болгохоос өмнө удирдлага нь шинэ харилцагч тус бүрийн эргэн төлөх чадварыг тусгайлан шинжилж, эрсдэлийн бодлогоо боловсруулдаг. Компанийн хяналт нь гадаад үнэлгээг авч үздэг, үүнд боломжтой бол санхүүгийн тайлан, зээлийн зэрэглэл тогтоох байгууллагын мэдээлэл, бизнесийн салбарын мэдээлэл болон зарим тохиолдолд банкны лавлагаа, тодорхойлолт багтдаг.

Харилцагч тус бүрээр төлбөр төлөх дэлгэрэнгүй хуваарь гаргах байдлаар түрээсийн авлагаас хүлээх эрсдэлийг хязгаарладаг. Компани харилцагчийн эрсдэлийг тус бүрт нь хянадаг. Компанийн стандарт, бодлого журамд зааснаар санхүүгийн түрээсийн гэрээний төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд түрээслэгчийн санхүүгийн хөрөнгийг эзэмших эрхтэй байх ёстой. Компани нь түрээслэгчийн эрсдэл болон санхүүгийн түрээсийн эх үүсвэрээс хамаараад урьдчилгаа төлбөрийг 15% - 30% хооронд байршуулахыг шаарддаг.

Компани нь мөн түрээсийн авлагын эрсдэлийн төвлөрлийг салбараар нь хянадаг ба эдгээр нь ихэвчлэн газар тариалан, тээвэр логистик, уул уурхайн салбарууд байна.

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Эрсдэлийн төвлөрлийн салбараар нь харуулбал

Дараах хүснэгтээр Компанийн түрээсийн авлагын (Тодруулга 9) нийт дүнг салбараар нь харуулав.

(Мянган төгрөгөөр)	2022.12.31		2021.12.31	
	Нийт эрсдэл	%	Нийт эрсдэл	%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй	54,628,593	65%	42,397,408	53%
Тээвэр ба логистик	14,623,313	18%	22,385,091	28%
Уул уурхай ба олборлолт	1,751,242	2%	2,452,281	3%
Үйлдвэрлэл	8,368,786	10%	9,082,774	11%
Эрчим хүч	4,439,769	5%	3,932,003	5%
	83,811,703	100%	80,249,557	100%
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(16,696,432)		(9,104,516)	
	67,115,271		71,145,041	

Дараах хүснэгтээр Компанийн түрээсийн авлагын нийт дүнг салбараар нь харуулав.

(Мянган төгрөгөөр)	2022.12.31	2021.12.31
Улсын салбар	57,019,733	45,215,151
Хувийн салбар	26,791,970	35,034,406
	83,811,703	80,249,557
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(16,696,432)	(9,104,516)
	67,115,271	71,145,041

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Зээлийн эрсдэлд өртөлт болон барьцаа хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг дараах байдлаар харуулав:

(Мянган төгрөгөөр)	2022.12.31		2021.12.31	
	Нийт эрсдэл	Барьцаа хөрөнгө	Нийт эрсдэл	Барьцаа хөрөнгө
Түрээсийн авлага	67,115,271	125,715,823	71,145,041	150,470,050

Хугацаа хэтэрсэн болон үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгө дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	Хугацаа хэтрээгүй үнэ цэнэ буураагүй	Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буураагүй*	Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буурсан	Нийт
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	47,608,642	-	-	47,608,642
Дансны болон бусад авлага	3,249	-	9,351,175	9,354,424
Түрээсийн авлага	5,940,190	8,404,679	69,466,834	83,811,703
Нийт дансны үнэ	53,552,081	8,404,679	78,818,009	140,774,769
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(7)	(240,485)	(25,621,030)	(25,861,522)
Хорогдуулсан өртөг	53,552,074	8,164,194	53,196,979	114,913,247
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдөр				
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,937,352	-	-	9,937,352
Хугацаатай хадгаламж	27,974,372	-	9,245,373	37,219,745
Дансны болон бусад авлага	2,146	-	-	2,146
Түрээсийн авлага	5,411,859	32,564,658	42,273,040	80,249,557
Нийт дансны үнэ	43,325,729	32,564,658	51,518,413	127,408,800
Үнэ цэнийн бууралтын алдагдлын сан	(167,634)	(2,851,234)	(15,331,021)	(18,349,889)
Хорогдуулсан өртөг	43,158,095	29,713,424	36,187,392	109,058,911

*Хугацаа хэтэрсэн/үнэ цэнэ буураагүй

Компани нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 90 хоногоос дээш хугацаа хэтэрсэн боловч тайлант үеийн дараа эргэн төлөлт хийгдсэн түрээсийн авлагыг Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буураагүй ангилалд бүртгэсэн. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр Хугацаа хэтэрсэн/ Үнэ цэнэ буураагүй ангилалд тайлант үеийн дараа төлөлт хийгдсэн 8.4 тэрбум төгрөгийн түрээсийн авлага ангилагдсан.

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Одоогийн байдлаар, Компанийн түрээсийн багц нь голчлон төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд олгосон санхүүгийн түрээсээс бүрддэг. Монгол Улсын Засгийн Газар болон Компанийн хувьцаа эзэмшигч нар эдгээр түрээслэгчдийн хугацаа хэтэрсэн түрээсийн авлагын эргэн төлөлтийг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллаж байна. Тухайлбал, Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 220 тоот тогтоол гарснаас хойш газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж буй түрээслэгчид хугацаа хэтэрсэн түрээсийн өр төлбөрөө төлж эхэлсэн. Түүнчлэн, Монгол Улсын Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн Үйлдвэрийн Сайдын 2022 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 01/2882 тоот “Өр барагдуулах талаар албан даалгавар өгөх тухай” тушаал, Монгол Улсын Засгийн Газрын 220 тоот тогтоолыг хэрэгжүүлэх тухай 2022 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн Монгол Улсын Засгийн Газрын хуралдааны тэмдэглэл тус тус гарсан.

2022 онд КОВИД-19-тэй холбоотой хязгаарлалтууд буурсантай холбоотой нүүрс болон зорчигч тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй түрээслэгчдийн бизнесийн үйл ажиллагаа сэргэж эхэлсэн. Эдгээрийн үр дүнд, Компани нь хөдөө аж ахуй, нүүрс болон зорчигч тээврийн салбарт үйл ажиллагаа явуулж буй тодорхой түрээслэгчид хугацаа хэтэрсэн авлага эрчимтэй барагдуулж, түрээсийн төлбөрөө үргэлжлүүлэн сайн төлж барагдуулах хандлагатай байгаа тул эдгээр түрээслэгчидтэй холбоотой зээлийн эрсдэл буурч, түрээсийн авлагын ангилал дээшлэн бага эрсдэлтэй ангилалд дахин ангилагдах боломжтой болж байна.

2) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл гэдэг нь зах зээлийн үнийн өөрчлөлт тухайлбал хүүгийн хувь, санхүүгийн түрээс болон гадаад валютын ханш өөрчлөгдсөнөөр Компанийн орлогод сөргөөр нөлөөлөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь хүлээн зөвшөөрөгдөх параметерүүдийн хүрээнд эрсдэлийг хянах, удирдсанаар эрсдэлийн өгөөжийг хамгийн оновчтой байлгах явдал юм.

(i) Ханшийн эрсдэл

Компанид бүртгэлийн валют болох төгрөгөөс өөр гадаад валютаарх түрээсийн авлага болон зээлээс валютын эрсдэл үүсдэг. Эдгээр ажил гүйлгээнүүд хийгддэг валютууд нь Ам.Доллар, Евро, Япон Иен болон Хятад Юань байна. Компани нь гадаад валютын хэлбэлзлийг тогтмол хянадаг ба валютын эрсдэлийг бууруулах зорилгоор ирээдүйд хийгдэх гадаад валютаарх мөнгөн урсгалыг хянадаг.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Ам.Доллар</u>	<u>Евро</u>	<u>Иен</u>	<u>Юань</u>	<u>Нийт</u>
Санхүүгийн хөрөнгө:					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1,740	23,589	5,635	938	31,902
Түрээсийн авлага*	<u>22,476,607</u>	<u>31,140,791</u>	<u>1,697,104</u>	<u>-</u>	<u>55,314,502</u>
	22,478,347	31,164,380	1,702,739	938	55,346,404
Санхүүгийн өр төлбөр	<u>-</u>	<u>-</u>	<u>-</u>	<u>-</u>	<u>-</u>
Цэвэр дүн	<u>22,478,347</u>	<u>31,164,380</u>	<u>1,702,739</u>	<u>938</u>	<u>55,346,404</u>

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

2) Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

(i) Ханшийн эрсдэл, үргэлжлэл

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар:

(Мянган төгрөгөөр)	Ам.Доллар	Евро	Иен	Юань	Нийт
Санхүүгийн хөрөнгө:					
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	613,743	1,096,646	26	859	1,711,274
Хугацаатай хадгаламж	4,510,764	-	6,050,160	-	10,560,924
Түрээсийн авлага*	17,073,055	20,830,227	1,439,808	-	39,343,090
	22,197,562	21,926,873	7,489,994	859	51,615,288
Санхүүгийн өр төлбөр					
Зээл	(7,157,641)	-	-	-	(7,157,641)
Цэвэр дүн	15,039,921	21,926,873	7,489,994	859	44,457,647

* Түрээсийн авлагын үлдэгдэл нь үнэ цэнийн бууралтын алдагдлын санг хассаны дараах дүн.

Тайлант үед валютын ханш дараах байдалтай байсан:

(төгрөгөөр)	Дундаж ханш		Тайлагналын өдрийн спот ханш	
	2022	2021	2022	2021
Ам.Доллар	3,141	2,849	3,445	2,849
Евро	3,304	3,372	3,669	3,223
Иен	24	26	26	25
Юань	466	442	495	447

(ii) Мэдрэмжийн шинжилгээ (татварын өмнөх дүн)

12 дугаар сарын 31-ний өдрөөрх гадаад валютын ханш 10 хувиар чангарах эсвэл сулрахад дараах хүснэгтэнд харуулсан дүнгээр буюу орлогыг татварын дараах байдлаар өсгөх (бууруулах) нөлөөтэй байна. Энэ шинжилгээ нь бусад бүх хувьсах хүчин зүйлсийг, тодруулбал хүүгийн хувь хэмжээг тогтмол гэж авч үзсэн болно.

(Мянган төгрөгөөр)	Ашиг/ (Алдагдал)	
	Чангарах	Сулрах
2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр		
Ам Доллар (10%-ийн өөрчлөлт)	2,247,835	(2,247,835)
Евро (10%-ийн өөрчлөлт)	3,116,438	(3,116,438)
Иен (10%-ийн өөрчлөлт)	170,274	(170,274)
Юань (10%-ийн өөрчлөлт)	94	(94)
2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр		
Ам Доллар (10%-ийн өөрчлөлт)	1,503,992	(1,503,992)
Евро (10%-ийн өөрчлөлт)	2,192,687	(2,192,687)
Иен (10%-ийн өөрчлөлт)	748,999	(748,999)
Юань (10%-ийн өөрчлөлт)	86	(86)

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

2) Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

(iii) Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн түвшний эрсдэл нь ирээдүйд хүүгийн түвшний хэлбэлзэл тэр дундаа хадгаламж болон зээлийн хөвөгч хүүнээс үүсэх эрсдэл юм. Хүүгийн түвшний эрсдлийн удирдлагын гол зорилго нь санхүүгийн зардал болон хүүгийн түвшний өөрчлөлттэй холбоотой тодорхойгүй байдлыг багасгах явдал юм.

Компанийн хүүгийн түвшний өөрчлөлтөөс хамааралтай зах зээлийн эрсдэл нь Компанийн зээлтэй үндсэндээ холбоотой байна.

Багц

Эрсдэлийг бууруулах Компанийн бодлого нь тогтмол хүүгийн түвшинтэй зээл авах юм. Тайлангийн өдрөөрх Компанийн хүүтэй санхүүгийн хэрэгслүүдийн багц дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)	2022	2021
Тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгө:		
Санхүүгийн хөрөнгө:		
Хугацаатай хадгаламж	-	27,974,372
Санхүүгийн түрээсийн авлага	67,115,271	71,145,041
	67,115,271	99,119,413
Санхүүгийн өр төлбөр:		
Санхүүгийн түрээсийн өр төлбөр	(20,587)	(55,641)
Зээл	-	(7,157,641)
	(20,587)	(7,213,282)
	67,094,684	91,906,131

(iv) Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь хорогдуулсан өртгөөр бүртгэсэн хугацаатай хадгаламж, түрээсийн авлага, дансны болон бусад авлага, хадгаламжаарх үнэ цааснаас бүрдэнэ. Удирдлага санхүүгийн тайланд тусгагдсан тэдгээр санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэй ойролцоо гэж үзэж байна.

3) Хөрвөх чадварын эрсдэл

Хөрвөх чадварын эрсдэл гэдэг нь Компани өөрийн санхүүгийн өр төлбөрийг барагдуулах үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болох эрсдэл юм. Компани нь хэвийн болон онцгой нөхцөлд их хэмжээний алдагдалд орохгүйгээр, Компаний нэр хүндэд хохирол учруулах эрсдэлийг бий болгохгүйгээр өр төлбөрөө гэрээний хугацаанд төлж барагдуулахад хүрэлцэхүйц хөрвөх чадварыг байнга барьж байх ёстой гэдэг зарчмаар хөрвөх чадварыг удирдан зохицуулдаг.

Компанийн хувьцаа эзэмшигч нь хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагыг хариуцдаг ба Компанийн богино, дунд ба урт хугацааны санхүүжилт болон хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын шаардлагад нийцсэн хөрвөх чадварын бүтцийг бий болгох үүрэгтэй. Компани санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийн төлөгдөх хугацаа, банкнаас зээл авах чадавхи, зээлийн ашиглагдаагүй үлдэгдэл, мөнгөн урсгалын таамаглал болон гүйцэтгэлд үндэслэн хөрвөх чадварын эрсдэлийг удирддаг.

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

3) Хөрвөх чадварын эрсдэл, үргэлжлэл

Дараах хүснэгтэнд 2022 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Компанийн санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг гэрээгээр хүлээсэн үүргийн эргэн төлөлтийн дискаунтчлаагүй дүнд суурилан дуусах хугацаагаар нь ангилан харууллаа:

	2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх					Нийт
	3 сараас доош	3-аас 6 сар	6 сараас 1 жил	1-ээс 5 жил	5 жилээс дээш	
Санхүүгийн хөрөнгө						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	47,610,547	-	-	-	-	47,610,547
Дансны болон бусад авлага	189,334	-	-	-	-	189,334
Түрээсийн авлага	73,252,750	6,839,296	2,964,085	8,758,218	1,199,054	93,013,403
	121,052,631	6,839,296	2,964,085	8,758,218	1,199,054	140,813,284
Санхүүгийн өр төлбөр						
Дансны болон бусад өглөг	(269,759)	-	-	-	-	(269,759)
Түрээсийн өглөг	(10,785)	(10,620)	-	-	-	(21,405)
	(280,544)	(10,620)	-	-	-	(291,164)
Цэвэр дүн	120,772,087	6,828,676	2,964,085	8,758,218	1,199,054	140,522,120

Ди Би Эм Лизинг ХХК

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн Санхүүгийн Тайлангийн Тодруулга

24. Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

(1) Санхүүгийн эрсдэлийн удирдлага, үргэлжлэл

3) Хөрвөх чадварын эрсдэл, үргэлжлэл

	2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх					Нийт
	3 сараас доош	3-аас 6 сар	6 сараас 1 жил	1-ээс 5 жил	5 жилээс дээш	
Санхүүгийн хөрөнгө						
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	9,938,358	-	-	-	-	9,938,358
Хугацаатай хадгаламж	27,994,716	-	-	-	-	27,994,716
Дансны болон бусад авлага	2,146	-	-	-	-	2,146
Түрээсийн авлага	50,470,913	6,879,138	14,067,433	17,869,832	2,981,196	92,268,512
	88,406,133	6,879,138	14,067,433	17,869,832	2,981,196	130,203,732
Санхүүгийн өр төлбөр						
Дансны болон бусад өглөг	(969,992)	-	-	-	-	(969,992)
Түрээсийн өр төлбөр	(10,200)	(10,200)	(20,400)	(21,397)	-	(62,197)
Зээл	(3,776,416)	-	(3,650,562)	-	-	(7,426,978)
	(4,756,608)	(10,200)	(3,670,962)	(21,397)	-	(8,459,167)
Цэвэр дүн	83,649,525	6,868,938	10,396,471	17,848,435	2,981,196	121,744,565

25. Капиталын эрсдэлийн удирдлага

Компани тасралтгүй үйл ажиллагаа явуулах зорилгоор өөрийн капиталыг удирдахын зэрэгцээ оролцогч талуудын өгөөжийг хамгийн ихээр байлгахын тулд банкин дахь дансны үлдэгдэл болон өөрийн хөрөнгийн харьцааг оновчтой байлгахыг зорьдог.

Компанийн капиталын бүтэц нь банкин дахь дансны үлдэгдэл, зээл, эздийн өмч ба өөрийн хөрөнгөөс бүрдэх бөгөөд өөрийн хөрөнгө нь дүрмийн сан ба хуримтлагдсан ашгаас тус тус бүрддэг.

26. Тайлант үеийн дараах үйл явдлууд

Тайлангийн үеийн дараа санхүүгийн тайланд тодруулга эсвэл залруулга шаардах томоохон үйл явдал гараагүй болно.

27. Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг Англи, Монгол хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хэл дээрх хувилбаруудын хооронд утга болон агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи хувийг баримтална.